

ХҮРЭМТИЙН ХАДНЫ ЗУРАГ

Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-Археологийн тэнхим
tgl@mitt.edu.mn

Түлхүүр үг: хадны зураг, дүрслэл, байршил, сэдэв агуулга

ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ: Энэхүү өгүүлэлд 2004 оны 7-8 сард Архангай аймгийн Цэцэрлэг сумын Бух багийн нутаг Хүрэмтийн хадны зургийг судалсан судалгааны талаар танилцуулж Хүрэмтийн хадны зургийн сэдэв, дүрслэлийг ангилан судалсан үр дүнг оруулсан болно. Хүрэмтийн хадны зураг нь Архангай аймгийн Цэцэрлэг сумын төвөөс баруун хойш 70 км-ийн зайд ($N49^{\circ}09'01''$; $E100^{\circ}42'08''$) оршиж байна.

Хүрэмтэд нийтдээ 12 газар хадны зураг тархсан бөгөөд янз бүрийн дүрслэлтэй 1176 хадны зураг бүхий томоохон цогцолбор газар юм. Хүрэмтийн хадны зургийн орчимд олон тооны хиргүүр, 2 буган хөшөө тэмдэглэгдсэн байна. Хүрэмтийн хадны зургийн 1-р талбай нь уртаашаа 275 метр, өргөөшөө 40 метр бөгөөд 406 хаданд 841 зураг байсан болно. Нийт талбайг 10x40 метрийн хэмжээтэй хэсэгт хуваан судалсан бөгөөд 3, 4, 10, 13, 14, 26 -р хэсгүүд хамгийн олон хадны зурагтай байлаа. Зургийн тархалтыг авч үзвэл 14-р хэсэгт 104, 26-р хэсэгт 84, 13-р хэсэгт 82, 10-р хэсэгт 62, 7-р хэсэгт 51, 3-р талбайд 39 зураг тус тус байлаа. Зургуудыг урлахдаа хадыг хонхойлгон сийлэх аргаар урласан бөгөөд нилэнхүйд нь хонхойлгон сийлэх, дурсний ерөнхий шугамыг хөвөөлөн гаргаад эх биеийн ерөнхий хэсгийг хадны өнгөөр үлдээх гэсэн дүрслэх хоёр арга хэрэглэсэн байна. Хүрэмтийн хадны зургийн үндсэн сэдэв нь эртний хүмүүсийн эрхлэх аж ахуйн(ан гөрөө, мал аж ахуй), зэр зэвсэг, тэрэг, гэр бүл, ахуй амьдрал, овгийн тамга тэмдэг, байгаль тэнгэр эрхсийг шутэж бишрэх ёсны талаарх ойлголт зэргийг багтаажээ.

ОРШИЛ

Монгол орны нутагт иргэншин амьдарч байсан эртний хүмүүсийн үлдээсэн хосгүй дурсгалуудын нэг нь хадны зураг юм. Тэдгээрийн хамгийн эртнийх нь палеолитын дээд үед холбогдох бөгөөд энэ үед хамаарах хадны зургууд манай орны Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойт Цэнхэрийн агуй, Ишгэн толгой, Буянт сумын Чандмань хар үзүүр, Увс аймгийн Сагил сумын Хад үзүүр, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад зэрэг газраас олдсон (Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг, 2002). Эдгээр хадны зургуудаас Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэрийн агуйн зургийг А.П.Окладников судлаад " Урлагийн эхлэл, түүний үндэс, анхны үүсвэр өрнө дахинд байсан шиг дорно дахинд Төв Азийн гүнд байсан" хэмээн дүгнэсэн байдаг(Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг, 2002). Палеолитын

үеийн хадны зургийн нэг онцлог нь уг дүрсийг олон дахин зурахын оронд зургийг дагалдуулан хуруугаар дарсан мэт толбуудыг дүрсэлдэг байжээ.

Монгол улсын нутаг дэвсгэрээс мезолитын үед холбогдох хэд хэдэн хадны зураг олдсон бөгөөд Рашаан хадны тамга дүрсүүд, Могоогийн хадны зураг, Бага газрын чулууны хадны зургуудыг нилээд судалсан. Энэ үеийн хадны зургийн нэг онцлог нь үржлийг бэлгэдсэн тэмдэг бүхий палеолитын үеийн уламжлалт арга, нум sumaар зэрлэг үхэр агнаж буй болон ан агнуур, үхрийг эхэлж гаршуулсан дунд чулуун зэвсгийн аж ахуйн сэдэв хамт нэг дор дүрсэлдэг бөгөөд амьтдын эвэр, их биеийг бодитой нилээд болхи дүрсэлдэг байна(Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг, 2002).

Неолитын үеийн хадны зургууд нь "X" маягийн солбисон зураасан тэмдэг, ганц ба хэд хэдэн эгнээ босоо зураасан тэмдгүүд, дугуй, гурвалжин хэлбэрийн тэмдгүүдээс ихэвчлэн бүрдэх бөгөөд энэ төрлийн зурагнууд Зураагийн улаан хад, Өвөрхөнгай аймгийн Дэлгэрэх сумын Цоорхойн агуй, Уянга сумын Шурангийн улаан хад, Баглуур хад, Төв аймгийн Зуун мод, Дунд говь аймгийн нутаг Гэр чулуу, Архангай аймгийн Жаргалант сумын Улиастайн гол, Дулааны үзүүр, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Зоргол хайрхан, Хэнтий аймгийн Биндэр сумын Бичигт хад, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй Цагаан агуй, Баян Өндөр сумын Саалтын агуй, Цагаан магнайн агуйгаас тус тус олдсон байна (Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг, 2002).

Монголын түүхийн энеолитын үед холбогдох зургуудын тоонд Архангай аймгийн нутаг Чулуут голын хөндийн хадны зургууд багтдаг бөгөөд дүрслэлийн хувьд харьцангуй өвөрмөц юм. Олон салаа бүхий хормойтой хувцас, шовх оройтой малгай өмссөн хүмүүс, данхар эвэртэй буга зэргийг голчлон сийлсэн байдаг(Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг, 2002).

Хүрэл зэвсгийн үед холбогдох хадны зургийг улаан зосон болон сийлмэл хадны зураг хэмээн ангилж үзнэ. Улаан зосон зураг нь зурсан он цаг болон утга агуулга дүрсээрээ харилцан адилгүй бөгөөд Улаанбаатар хотын Богд хаан уулын Их тэнгэрийн ам, Гачууртын ам , Хөвсгөл аймгийн Баянзүрх , Гачууртын бичиг, Улаан уул сумын нутаг Толжийн боом, Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сумын Зэлтэрийн голын Цагаан Оломын гарамны дэргэдээс, Хүйтний голын бичигт хад, Шарын голын Цагаан нуур, Хэнтий аймгийн Дадал сумын Балжийн хавцгай, Булган аймгийн Орхон сумын Баруун могойн гол, Орхон гол, Бугат сумын Бичигт хад зэрэг газраас олджээ. Эдгээр зургууд нь төв хэсэгтээ олон дугуй толбо бүхий дөрвөлжин хашлага болон дугуй хүрээг зурсанаараа онцлог

бөгөөд хөтлөлцөн хүмүүс, адуу хөтлөсөн хүн зэргийг дүрсэлсэн нь түгээмэл байна. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутаг “Тэмээн чулууны ам” -ны хадны зураг болон Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Бэндэрьяа уулын Дугана хадны зургууд нь эдгээрээс онцлогтой бөгөөд дөрвөлжин булшны хананд өрөөсөн гаралт өргөн эгнэн зогссон олон хүмүүсийг дүрсэлжээ.

Харин хүрлийн үеийн сийлмэл зургууд нь нилээд түгээмэл бөгөөд зохиомж, сийлсэн арга барил, холбогдох он цагийнхаа хувьд харилцан адилгүй. Хүрэл зэвсгийн дунд үеэс амьтныг дүрслэхдээ загварчлан дүрсэлж эхэлсэн. Дүрслэлийн хувьд ан амьтдыг ганц нэгээр болон сүргээр нь үйл явдал дунд дүрсэлсэнээс гадна ан хийж буй анчид, дайтаж буй дайчин эрс, тэрэг түгээмэл тохиолддог. Сийлмэл зургууд нь Баянхонгор аймгийн Баянлиг сумын Их Баян уулын Бичигтийн ам, Шинэжинст сумын Цагаан хаалга, Гэцэлийн ус, Сонгинот, Бууцагаан сумын Гурван мандал, Баян-Өлгий аймгийн Цагаан салаа, Бага Ойгор, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Өвгөнт, Үүдэнт, Хөтөл өтгө, Орхон сумын Орхон гол, Баруун могоян гол, Архангай аймгийн Цэцэрлэг сумын Хонгоржин, Ховд аймгийн Үенч сумын ямаан ус, Хэнтий аймгийн Батширээт сумын Үзүүр цохио, Рашаан хад Өмнөговь аймгийн Ноён сумын Аравжих, Булган сумын Хавцгайт, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Гучин ус сумын Их Дөрөлж, Паалуу, Увс аймгийн Сагил сумын Гурвантурга, Хандгайтын гол, Можоо, Бужаа, Төмөр цорго, Эхэн хүзүүвч, Өмнөговь сумын Шар булгын онц, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Могоян толгойн хаданд дүрслэгдэн үлджээ.

Энэ бүхнээс хараад цаг хугацааны хувьд харилцан адилгүй сэдэв, дүрслэл, агуулгын хувьд маш олон төрлийн хадны зураг монгол орны ихэнх нутагт өргөн тархжээ. Энэхүү өгүүлэлдээ 2004 оны 7-8 сард Архангай аймгийн Цэцэрлэг сумын Бух багийн нутаг Хүрэмтийн хадны зургийг судалсан судалгааны үр дүнгээс танилцуулж Хүрэмтийн хадны зургийн сэдэв, дүрслэлийн тухай асуудлыг хөндөж шинжлэх ухааны эргэлтэнд оруулахыг зорьсон юм.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол оронд эртний хүмүүсийн зурж сийлж үлдээсэн урлагийн бүтээл болох хадны зургийн дурсгалыг судалсан судалгааны түүхийг авч үзвэл анх 1889 онд одоогийн Төв аймгийн Алтанбулаг сумын Тариат бригадын нутаг Улаан хад хэмээх газрын хадны зургийг Оросын эрдэмтэн Н.М. Ядринцев судалснаар эхэлжээ. Түүний дараа 1891 онд академич В.В.Радлов Хануйн гол, Орхон голын сав нутаг дахь хадны зургийг, 1893 онд Д. Клеменц Тайхар

чулууны түрэг бичгийг, 1925 онд Г.И.Бровка Төв аймгийн нутаг Их алаг уул, Дөрвөлжин уулын хадны сийлмэл зургийг, 1950 оны эцсээр К.В. Вяткина Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутаг Шунхтай уулын орчим дахь хадны зургийг тус тус судлан нийтлүүлсэн байна (Санжмятав, 1995)

Монгол орны өргөн уудам нутагт хийсэн эртний судалалын судалгаагаар 13 зууны үеийг хүртэлх түүхэн үеүдэд холбогдох дурсгалуудыг нээн илрүүлсний дотор хадны зургийн судалгаа зохих байр сууриа хэдийн олжээ. Ховд аймгийн Манхан сумын нутаг дахь "Хойд цэнхэр"-ийн агуин хаданд улаан зосоор зурсан амьтдын зургийг О.Намнадорж (1954) олж анх судалгааны эргэлтэнд оруулсан. Түүний дараа Монгол-Зөвлөлтийн хамтарсан Археологийн шинжилгээний анги Хойд Цэнхэрийн агуин зургийг нарийвчлан судалж акамемич А.П.Окладников (1972) судалгааны үр дүнг хэвлэн нийтлүүлсэн байна. Энэ үеэс эхлэн хадны зургийг судлах шинжлэх ажил эрчимжиж археологич Ц.Доржсүрэн (1957) Увс аймгийн Давст сумын нутаг Хатуугийн Мөнгөн Цахиуртын хадны зургийг, Н.Сэр-Оджав (1957) Архангай аймгийн Өндөрсант сумын нутаг Цэцэгтийн ам, Ховд аймгийн Дарви сумын нутаг Баян Өндөрийн Бичигт хадны зураг, Баян-Өлгий аймгийн Уйгар сумын нутаг Хөх хөтөлийн Тост Өтгийн хадны зураг, Увс аймгийн Туруун сумын нутаг Байцын голын Бугатын аман дахь хадны зургууд, Өвөрхангай аймгийн Дэлгэрэх сумын нутаг Баян -Улаан уул, Их цоорхойн агуй, Уянга сумын нутаг Шурангийн бичигт улаан хадны зосон зургийг судалсан байна (Санжмятав, 1995).

А.П.Окладников (1962) Улаанбаатар хотын өмнө орших Богд уулын архомой дахь Бяцхан толгойн хадны зургийг, Д.Дорж (1962) Төв аймгийн Алтан булаг сумын нутаг Их алаг ба Бүрэн сумын нутаг Бичигт улаан хадны зургийг судалсан төдийгүй тэрээр анх монголын хадны зургийн судалгааны тоймыг нэгтгэн он цагийн асуудлыг хөндсөн байна. Ц.Доржсүрэн (1963) Говь- Алтай аймгийн Наран, Цээл сумын зааг нутаг Цагаан голын хадны зураг, Д.Дорж (1963) Улаанбаатар хотын ойролцоо Их тэнгэрийн ам, Гачууртын ам, Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Улаан уул сумдын заагт орших хадны зосон зургийг, Дорноговь аймгийн Хатан булаг сумын нутаг дахь хадны зураг, С.Бадамхатан (1963) Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Бичигт булан, Ичээтийн Гозгор, Улаан уул сумын Толжийн боом, Ринчинлхүмбэ сумын Зээрдэгчин, Ангиртагийн овооны хүрэн зосон ба сийлмэл зургийг тус тус судалжээ.

Х.Пэрлээ (1960) Тайхар чулуу, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэрхаан уулын өвөр бэлд орших Раашан хадны зургийг, А.П.Окладников

(1964), Н. Сэр-Оджав (1977), Д.Дорж (1969, 1975) нар Өвөрхангай аймгийн Богд сумын Ховд бригадын нутаг Тэвш уулын хадны зургийг судалсан байна. 1969 оноос В.В.Волков, Д.Наваан нар Ховд аймгийн Үенч сумын нутаг Ямаан усны ханан хадны сийлбэр зургийг, 1972 онд Н.Сэр-Оджав Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Бичигтийн амны сийлбэр зургийг, Монгол-Германы хамтарсан геологи шинжилгээний анги Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Түйн голын хадны зургийг нээн судалжээ. Түүний дараа Ц.Шагдарсүрэн (1974), Д.Цэвээндорж (1977), Б.Чогсом (1979), Э.А.Новогородова (1981,1982,1984), Т.Санжмятав (1981, 1982, 1983) нарын олон эрдэмтэн судлаачид монгол орны өргөн уудам нутагт тархсан хадны зургийг судалсан бөгөөд тэдний дундаас Н.Сэр-Оджав, Д.Дорж, Д.Наваан, Э.А.Новогородова, Ю.С.Худков, Т.Санжмятав, Д.Цэвээндорж нарын эрдэмтэд олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавин хэлэлцүүлсэн нь хадны зургийн судалгааг олон улсын төвшинд хүргэсэн төдийгүй тухайн түүхэн үеийг гүнзгийрүүлэн судлахад чухал хэрэглэгдэхүүн болж байна.

Архангай аймгийн Тариат сумын нутаг Чулуут голын хадны сийлбэр зургийг Оросын эрдэмтэн геологич П.В.Коваль анх нээсэн бөгөөд уг дурсгалыг В.В.Волковын удирдсан Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн "Хүрэл, төмрийн түрүү үе судлах" анги удаа дараалан судалжээ (Санжмятав, 1995). Энэхүү хадны зургийн он цагийн асуудлыг А.П.Окладников, Э.А.Новогородова (1981) нар хөндөн ном бичиж хэвлүүлжээ. Археологич Т.Санжмятав (1982,1987) Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Бичигт хадны зургийг судалсаны зэрэгцээ Чулуут голын хадны зургийн эх хуулбарыг бүрэн хийж хэд хэдэн өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна. Мөн Архангай аймгийн Жаргалант сумын Улиастайн гол, Дулааны үзүүрт неолитын үед холбогдох хадны зургууд болон хүрлийн үед холбогдох Архангай аймгийн Цэцэрлэг сумын Хонгоржины хадны зургууд судалгааны эргэлтэнд аль хэдийн оржээ.

Харин Архангай аймгийн Цэцэрлэг сумын Бух багийн нутаг Хүрэмтийн хадны зургийн дурсгал өмнө судлагдаагүй билээ.

МУИС-ийн НШУС-ийн Антропологи-Археологийн тэнхмийн багш Ц.Цэцэгжаргалаар удирдуулсан Монгол Улсын Их Сургууль болон Английн Эдинбургийн Их Сургууль, Ньюкастлийн Их Сургуулийн оюутнуудын баг Хүрэмтийн хадны зургийн нарийвчлэн судлах зорилгоор 2004 оны 7-8 сард уг газар ажилласан болно. Судалгааны гол зорилго нь тухайн нутаг дахь хадны зураг болон бусад археологийн дурсгалуудын газар зүйн байршлыг GPS –ээр

Хүрэмтийн хадны зураг

тодорхойлон археологийн дурсгалуудын тархалтыг харуулсан дижитал газрын зураг зохиох, хадны зургуудыг фото каталогид оруулах, цуглувалсан судалгааны материалд анализ хийж шинжлэх ухааны эргэлтэнд оруулах зэрэг болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хүрэмтийн хадны зургийг судлахдаа:

- Нутгийн хүмүүстэй ярилцлага хийн тус нутаг дахь хадны зургийн талаар мэдээлэл цуглувулах
- Явган болон завиар явж хайгуул судалгааг хийж хадны зураг бүхий газрын байршлыг GPS-ээр нарийвчлан тогтоох
- Ихэнх дурсгалт газрууд дахь хадны зургуудын
 - байршил
 - дурсгалт газруудын нарийвчилсан хэмжээ
 - дүрс бүхий хадны тоо болон хадан дээрх дүрслэлийн тоо
 - дүрслэлийн төрлүүд болон үйлдсэн хэв маяг бүрийг нэг бүрчлэн тодорхойлох зэрэг ажлыг гүйцэтгэв.

Цаг хугацааны боломжоос шалтгаалан зарим талбай дахь хадны зургийг тоймлон тэмдэглэсэн болно.

Манай судалгааны баг хамгийн олон хадны зураг бүхий 1-р талбайд төвлөрч ажиллав. Энд уртаашаа 275метр, өргөөшөө 40 метрийн талбайд хадны зураг тархсан байсныг дараахи байдлаар судаллаа. Үүнд:

1. Талбайн доод захад үндсэн шугам татаж, түүнээс дээш өгсөөн хоорондоо 10 метрийн зйтай шугмуудыг татан нийт талбайгаа 10x40 метрийн хэмжээтэй 28 хэсэгт хуваан судалгаа хийх
2. Хэсэг бүрийн зурагтай хаднуудыг дугаарлан тэмдэглэж байршлыг GPS-ээр тодорхойлохоос гадна тус зурагтай хад хэсгийн зүүн болон үндсэн шугамаас хэдэн метрийн зайд байгааг хэмжиж, хадны зүг чиг болон дүрс бүхий хадны нүүрэн хэсгийн өнцгүүд, хадны төрлийг тодорхойлох
3. Амьтны болон хүний үйл ажиллагаатай холбоотой гэмтэл, байгалийн хүчин зүйлийн нэлөөг (хадны төлөв байдал(хаг/цууралт/нүх)) тодорхойлох
4. Хадны зургийн ерөнхий зураглал (амьтдын харсан зүг, хөл, толгой гэх мэт), тоо, төрөл, үйлдсэн арга барил зэргийг багтаан тэмдэглэл хөтлөх
5. Дурсгалт газрууд, тухайн хэсэг, хадны зураг тус бүрийн зургийг дижитал аппаратаар авах


6. Өвөрмөц зургуудыг бодит хэмжээгээр буулган авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

Хадны цөөн зураг бүхий талбайг судлахдаа дээрхийн нэгэн адил хэсгүүдэд хуваах шаардлага байгаагүй. Харин бусад тэмдэглэлүүдийг дээрхийн адил хөтлөв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хадны зураг судлах Монгол-Британийн оюутнуудын хамтарсан судалгааны баг 2004 оны 7 сарын 24 - 8 сарын 25-ыг хүртэл Архангай аймгийн Цэцэрлэг сумын Бух багийн нутаг Хүрэмт хэмээх газарт орших хадны зургийг судлах ажлыг гүйцэтгэсэн болно. Уг судалгааны багт МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхмийн багш Ц.Цэцэгжаргал, тус тэнхмийн 4-р ангийн оюутан Л.Тайванбаяр, Б.Амартувшин, Э.Эрдэнэсүрэн болон Ньюокэстлийн Их Сургуулийн оюутан Наташа Чамберлин, Брайни Морган, Катрин Стивинсон, Эдинбургийн Их Сургуулийн оюутан Сара Наррер нар ажиллав.

Хүрэмтийн хадны зургийн дурсгал Архангай аймгийн Цэцэрлэг сумын төвөөс баруун хойш 70 км-ийн зайд ($N49^{\circ}09'01''$ болон $E100^{\circ}42'08''$) оршдог. Уг дурсгалт газар нь Чулуутын голын адагт орших бөгөөд Хүрэмтээс холгүй Идэр, Чулуут, Бөгсийн голууд болон Дэлгэр мөрөн нийлж Сэлэнгэ мөрөнд цутгадаг ажээ.



Зураг 1. Аяллын маршрут


Хүрэмтэд нийтдээ 12 талбайд хадны зураг тархсан бөгөөд янз бүрийн сэдэв бүхий 1176 дүрслэлтэй хадны зургийн томоохон цогцолбор газар юм. Үүнээс 2, 7, 10, 11 болон 12-р талбай нь хиригсүүртэй ойролцоо буюу хиригсүүр

Хүрэмтийн хадны зураг

дунд байрлаж байв. Хүрэмтийн хадны зургийн орчимд олон тооны хиригсүүр, 2 буган хөшөө олж илрүүлсэн болно.


Энэхүү өгүүлэлдээ Хүрэмтийн хадны зургийн 1-р талбайд хийсэн судалгааны үр дүнгээс сэдэв, дүрслэлийн асуудлыг орууллаа.

Хүрэмтийн хадны зургийн 1-р талбай нь уртаашаа 275 метр, өргөөшөө 40 метр бөгөөд 406 хаданд 841 зураг дүрслэгджээ. Нийт талбайг 10x40 метрийн хэмжээтэй 28 хэсэгт хуваан судалсан бөгөөд 3, 4, 10, 13, 14, 26 –р хэсгүүдэд хамгийн олон хадны зураг дүрслэлсэн байна. Дүрсийн тархалтыг авч үзвэл 14 хэсэгт 104, 26-р хэсэгт 84, 13-р хэсэгт 82, 10-р хэсэгт 62, 7-р хэсэгт 51, 3-р хэсэгт 39 дүрс тус дүрслэгджээ. Зургуудыг урлахдаа хадыг хонхойлгон сийлэх арга хэрэглэснээс гадна зургийг нэлэнхүйд нь хонхойлгон цохих, биеийн ерөнхий тэг шугамыг хөвөөлөн гаргаад эх биеийн ерөнхий хэсгийг хадны өнгөөр үлдээх гэсэн дүрслэх хоёр арга барил хэрэглэсэн нь харагддаг. Ийнхүү хонхойлж цохих аргаар дүрслэлсэн зургуудыг судлаачид МЭӨ II мянган жилийн сүүлийн хагасаас МЭӨ I мянган жилийн тэргүүн хагаст хамааруулан үздэг (Санжмятав, 1995). Түүнчлэн Хүрэмтийн хадны зургууд дахь амьтадыг бодит байдлаар болон загварчлан дүрслэх гэсэн хоёр аргаар урлажээ.



Зураг 2. Хүрэмтийн хадны зургийн 1-р хэсэг дэх дүрсийн агуулга, төрлүүд

1-р талбай дахь хадны зургийн ихэнх нь амьтдыг дүрслэлсэн бөгөөд тамга, багаж зэвсэг, хүн, тэрэгний дүрслэл цөөнгүй байлаа. Мөн нийт дүрслэлийн 21.6 хувийг тодорхойлох боломжгүй байсныг дурьдах хэрэгтэй. Хамгийн олон тархсан амьтдын дүрсийг төрлөөр нь ангилж үзвэл тэдний зонхилох хэсгийг янгир, буга, морь эзэлж байлаа.



Зураг 3. Хүрэмтийн 1р хэсэг дэх амьтад (төрлөөр)

Хүрэмтийн хадны зургийн сэдэв, дүрслэлийн асуудал

Монгол орны байгалийн хад чулуун дээр эртний хүмүүсээс зурж, сийлж үлдээсэн зураг сүгийн дурсгал нь дүрслэл, утга зүй, үүсэл гарлын хувьд хүн төрөлхтний түүхэн хөгжлийн янз бүрийн үед хамаардаг юм.

Судалгаанд оруулж байгаа Хүрэмтийн хадны зургийн үндсэн сэдэв нь эртний хүмүүсийн эрхлэх аж ахуйн(ан гөрөө, мал аж ахуй), зэр зэвсэг, тэрэг, гэр бүл ахуй амьдрал, овгийн тамга тэмдэг, байгаль тэнгэр эрхсийг шүтэж бишрэх ёсны талаарх ойлголт зэргийг багтаасан байна.

1. Аж ахуйн сэдэвт зураг

а. Агнуурын сэдэвт зураг

Хүрэмтийн хадны зурагт олон төрлийн ан амьтан дүрслэгдсэн төдийгүй ан агнуур хийж буй утга санааг илэрхийлсэн зураг хэд хэд байгаа юм.

Монгол оронд олон төрлийн ан амьтдыг агнан амьдарч байсан эртний анчдын агнуурын арга ухаан ба зэр зэвсэг үеэс үед улам сайжирч нэр төрөл, хэлбэр, хэмжээ, зориулалт нь өөрчлөгдсөн сайжирч боловсронгуй болсоор иржээ (Санжмятав, 1995). Өгүүлэн буй хадны зурагт нум сумтай анчдыг дүрсэлсэнээс гадна ангийн хутгыг олноор дүрсэлсэн байна. Хутганы хэлбэр төрхийг харвал буган чулуун хөшөөнд олноор дүрслэгдсэн цагирган бариулт тээглүүрт болон хуйтай хутгануудтай төстэй байлаа.

Тухайн бүс нутагт оршин амьдарч байсан хүмүүсийн агнуурын гол амьтад нь буга хандгай, янгир, гахай, чоно, аргаль байсан нь хадны зураг дээрх амьтны дүрслэлүүдээс харахад тодорхой байна. Хүрэмтийн хаданд нийт 265 янгирын дүрсийг, цөөн тооны аргалийг бодитойгоор дүрсэлжээ. Бугыг дүрсэлсэн



Зураг 1. Ангийн хугта



Зураг 2. Нум сум хэрэглэн ан аgnаж буй
анчин

арга барилыг авч үзвэл бугын төрхийг хэн ч харсан үнэмшилтэй бодитой болон хэлбэрдмэл байдлаар гэсэн 2 хэлбэрээр дүрсэлсэн бөгөөд Хүрэмтийн хадан дээрх бугын хэлбэрдмэл аргаар урласан дүрслэл нь буган чулуун хөшөөнд дүрсэлсэн бугын зурагтай адилхан байна. Судлаачид бугыг хэлбэрдмэл байдлаар дүрслэхийг МЭӨ III мянган жилийн эцэс, I мянган жилийн эхэн үед хамааруулан үздэг (Санжмятав, 1995). Ийнхүү бугын урт нарийхан хошуутай, хээ угалз мэт олон салаа урт эвэртэй, гоёмсог урт биетэйгээр загварчлан харуулж дүрслэх аргыг Ази, Европын эртний урлаг судлалд “Амьтныг загварчлан дүрслэх арга” гэж нэрлэдэг бөгөөд анх хүрэл зэвсгийн үед Монгол, Төв Азийн нутагт үүсчээ (Санжмятав, 1995).

Түүнчлэн бугыг ганц хоёроор буюу сүргээрээ мөн буга, согоо үр төлөө дагуулын идээшилж байгаа, үржилд орж байгаа зэргээр дүрслэлжээ. Мөн бодон гахайг бодитой буюу болхидуу хэлбэрээр ганц нэгээр нь, цөөн тооны чоно, мөгий, шувуу дүрслэгдсэн байна.


Ан агуурын холбогдолтой зан үйл хийж, сүлд тэмдэг хэрэглэж байсныг харуулах зураг ч тааралдаж байлаа.

б. Мал аж ахуйн сэдэвт зураг


Малын сүг зургууд Архангай аймгийн нутаг Чулуутын хадны зураг, Ховд аймгийн нутаг Хойд Цэнхэрийн гол, Өмнөговь аймгийн нутаг Уртын голын хад, Далан уул, Дунд говь аймгийн нутаг Дэл уулын хаданд түгээмэл байдаг (Санжмятав, 1995).

Хүрэмтийн хадны 1-р талбайд морь, ямаа, тэмээ зэрэг мал аж ахуйн сэдэвт зураг цөөнгүй дүрслэгдсэн байна. Адууг уналагын зориулалтаар төдийгүй тэргэнд хөллөн хэрэглэж буйгаар дүрслээд зогсохгүй сүргээрээ бэлчээрлэж байгаагаар нилээд тодорхой дүрсэлсэн бол тэмээ, ямааг ганц нэгээр нь дүрслэлжээ. Зураг 3 дээрх дүрсийг Хүрэмтийн хадны зураг дахь

янгирын дүрслэлээс ялгаатайгаар харьцангуй өөрөөр дүрсэлсэн учраас ямаа гэж үзлээ.




Зураг 3. Ямаа



Зураг 4. Тэмээ

Хүрэмтийн хадны зурагт цөөн тооны тэмээг дүрслэхдээ толгой, 2 бөхийг жижиг их биеийг хүдэр болхи, болоно хөлтэйгээр дүрсэлжээ.

Зураг 5 дээр жижиг толгойтой, биеэр турьхан, өндөр зэгзгэр биетэй адуу дүрсэлсэн байхад бусад зурган дээр дүрслэгдсэн морьд (зураг 6) нь харьцангуй бахим биетэй, гэдэс ихтэй, урт сүүлтэй, болоно хөлтэй байгааг Археологич Т.Санжмятавын хадан дээрх адууны зургийн ерөнхий хэлбэр төрхөөр нь угуул нутгийн болон гаднаас авч ирсэн адуу хэмээн ангилж үзсэнтэй дүйцүүлэн үзэж болох юм.



Зураг 5 . Адуун сүрэг



Зураг 6. Нутгийн морь

2. Зэр зэвсэг

Хүрэмтийн хадны 1-р талбай дахь нийт зургийн 3.8 хувийг багаж зэвсгийн дүрслэл эзэлж байгаагийн дийлэх хувийг янз бүрийн хэлбэр хэмжээтэй хүрэл хутга эзэлж байгаа юм. Хадан дээр зурсан хүрлийн үеийн эдийн соёлын зүйлээс хамгийн олон нь нум сумны дүрс байдаг бөгөөд хүрэмтийн хадны зурагт ч цөөнгүй тооны нум тохиолдож байна. Зураг 7 - аас харахад хүрэл зэвсгийн эхэн үеэс хэрэглэгдэх болсон чимээ гаргах зориулалтаар зэвний дэлбээнд цооног нүх гарган урласан “Дуут зэв”-ын хэрэглэдэг байсан нь бололтой.

Хүрэмтийн хадны зураг



Зураг 7. "Дуут зэв" бүхий нум сум




Зураг 8. Цагирган бариултай тээглүүрт хутга

Хадны зурагт ахуйн хэрэгцээний сүх, хутга, царил, зээтүү, жад, ооль, цавчуур, сүхэн алх, цоолтуур, цүүц дэгээ, шор мэт янз бүрийн дүрсийг нилээд дүрсэлсэн байдаг. Хүрэмтийн хадны зурагт ангийн, ахуйн зориулалтын хутганы дүрсүүд маш олон байна.




Зураг 9. Хос цагирган бариултай тээглүүрт хутга




Зураг 10. Ангийн том жижиг хутганууд

Хүрэмтийн хадны зурагт олон тоогоор тохиолдож байгаа цагирган, хос цагирган бариултай болон хуйтай хутганууд нь Ховд, Завхан, Хөвсгөл зэрэг аймгийн нутагт байгаа буган чулуун хөшөөнд дүрслэгддэг хутгануудтай адилхан байна.



Зураг 11. Хуйтай хүрэл хутга



Зураг 12. Хоёр морь хеллесен тэрэг

3. Тэрэг

Монгол нутагт амьдарч байсан овог аймгийн үлдээсэн чухал дурсгалын нэг бол хад чулуун дээр сийлж уралсан тэрэгний зураг юм. Хүрэмтийн хадны 1-р талбайн хадны зургийн 0.6 хувийг тэрэг эзэлж байгаагаас хамгийн өвөрмөц нь хос морь хөллөсөн хигээсгүй 2 жижиг дугуйтай тэрэг юм. Ийм тэрэгний зургийг Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутаг “Бичигт толгой”-н хадны зурагт дүрсэлсэн байдгийг археологич Д.Дорж, Э.А. Новогородова (1975), мөн аймгийн Цагаан голын хаданд дүрсэлснийг археологич Ц.Доржсүрэн (1963) нар тус тус нийтэлсэн байна. Археологич Т.Санжмятав “Монголын хадны зураг” номондоо мал аж ахуй үүсэн, мал сүргийн бүтэц тогтсон ялангуяа адууг унаа болгон хэрэглэх болсноор тэрэгтэй болох нөхцлийг бүрдүүлжээ” хэмээн үзсэн (Санжмятав, 1995).

4. Тамга тэмдэг

Хадны зурагт маш олон тооны тамга тэмдэг байх бөгөөд Х. Пэрлээ, А.П.Окладников, Д.Дорж, Э.А.Новогородова, Д.Цэвээндорж, А.П.Конопацкий зэрэг эрдэмтэд тамга тэмдгийн зүйлсийг бүртгэн ангилж судалгаа хийсэн байна(Санжмятав,1995). Хадны зурагт эртний олон овог аймгийн тамгыг дүрсэлсэн нь нэн их бөгөөд тэдгээрийн дотор онгин сэрээ, хайллага, чагтан болон янгир тамга түгээмэл тохиолддог.

Хүрэмтийн хадны зургийн 1-р талбайд нийт 35 тамга дүрслэгджээ. Хадны зургийн доторх тамгыг овгийн тамга, ямар нэгэн бэлэгдлийн утга санаа бүхий тэмдэг, үсгийн зурлага, тоо хэмжээ гэж ангилж болох юм хэмээн археологич Т. Санжмятав үзсэн байна(Санжмятав,1995). Хүрэмтийн хадны зураг дахь тамга тэмдгийг дээрх ангиллаар авч үзвэл ихэнх нь үндсэн болон овгийн тамга байлаа.



Зураг 13. Тамга



Зураг 14. Тамга

Хүрэмтийн хадны зураг



Зураг 15. Тамга



Зураг 16. Тамга



Зураг 17. Тамга



Зураг 18. Тамга

Эдгээрийн дотор хас тэмдгийн эх үүсвэртэй холбон авч үзмээр дөрвөн амьтны толгойн дүрслэл сонирхол татаж байлаа.

5. Гэр бүл ахуй амьдралын сэдэвт зураг

Хүрэмтийн хадны зургууд дунд мал хариулж яваа, ан агнаж буй зэрэг хүмүүсийн өдөр тутмын хөдөлмөрийн сэдэвт хэд хэдэн зураг тааралдлаа.



Зураг 19. Адуучин



Зураг 20. Гэрийн гадаа

Адууг эрхэмлэн унаа болгож хэрэглэх болсон хүрлийн үеийн хадны зургуудад эдгээр зураг шиг морь хөтөлсөн, унсан байдлаар урласан байдаг нь түгээмэл тохиолддог ажээ.

Энэ зурагнууд дундаас хамгийн сонирхолтой нь гэр бүлийн амьдралыг харуулсан байж болохоор эрэгтэй эмэгтэй 2 хүн гараасаа хөтлөлцөн хүүхэд дагуулан олон амьтдын дунд алхаж яваа зураг байлаа.



Зураг 21. Гэр бүлийн зураг

6. Байгаль тэнгэр эрхсийг шүтэж бишрэх ёс

Монголчууд эрт үеэс бугыг эрхэмлэн үзсээр ирсэн билээ. Хүрэмтийн хадны зураг дотор бугын эвэрийг од хэлбэртэй дүрсэлсэн хэд хэдэн зураг олдсон нь эрт үеэс бугыг тэнгэрээс заяатай амьтан хэмээн шүтэж ирсэнтэй холбоотой байж болх юм.



Зураг 22. Одон эвэрт буга (1)



Зураг 23. Одон эвэрт буга (2)

Мөн Монголын Нууц Товчоонд дээд тэнгэрээс заяат Бертэ Чоно Гуа марал 2 хэмээн өгүүлдэг шиг чоно буга хоёрыг нэг том чулуун дээр маш урнаар дүрсэлсэн нь сонирхол татаж байлаа.

Хүрэмтийн хадны зураг



Зураг 24. "Бөртэ чоно Гуа марал"

Хүрэмтийн хадны зургийн хадгалалтын асуудал

Хүрэмтийн хадны зураг бүхий маш олон хад цаг агаарын нөлөөнөөс шалтгаалан элэгдэл, цууралт, хагаралтад өртсөнөөс гадна шувууны сангаст дарагдах болон малын хөлөөр зурагдах зэрэг амьтны сүйтгэлд нилээн өртжээ. Мөн нийт тэмдэглэгдсэн хадны 22 хувьд нь орчин үеийн хүмүүс янз бүрийн дүрс тэмдэглэх, давхарлаж зурах зэргээр гэмтээсэн байна.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хийхэд санхүүгийн тусламж үзүүлсэн дараах байгууллагуудад талархал илэрхийлж байна. Үүнд:

- The Royal Geographical Society, UK
- Newcastle University Exploration Council, UK
- Edinburgh University Student Travel Fund, UK
- Harry Collinson Travel Scholarship, UK
- The Society of Antiquaries, UK
- The Royal Scottish Geographical Society, UK
- The Gordon Foundation, UK
- St Edward's School, Oxford, UK
- The Albert Reckitt Trust, UK
- The Gilchrist Educational Trust, UK
- New York Explorer's Club Youth Activity Fund, UK
- Duke of Edinburgh's Expedition Fund, UK
- 2111 Earth and Space Foundation, UK

НОМ ЗҮЙ

БНМАУ-ын түүх, Боть-1, УБ, 1984

Дорж Д., 1963. Монголын хүрлийн үеийн хадны зураг. Эртний судлал -угсаатны зүйн бүтээл. УБ

Дорж Д., Новогородова Э.А., 1975. Петроглифы Монголии, УБ

Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал, 1999, УБ

Монголын соёлын түүх, 1999. Боть-1, УБ

Новогородова Э.А., 1984. Мир петроглифов Монголии, М

Санжмяаев Т., 1995. Монголын хадны зураг, УБ
Сэр-Оджаа Н., 1987. Баянлигийн хадны зураг, УБ
Цэвээндорж Д., Баяр Д., Цэрэндагва Я., Очирхуяг Ц., 2002. Монголын археологи. УБ

SUMMARY

Ts.Tsetsegjargal

ROCK ART IN HUREMT

In Mongolia there are many rock art sites, many of them have not yet been documented or recorded in detail. The British- Mongolian joint expedition has done rock art survey in the Bukh bag (subdistrict), Tsetserleg sum (district), Arkhangai aimag (province) during August, 2004.

During the expedition there are discovered and recorded several rock art sites in the Huremt of Bukh bag, Tsetserleg sum, Arkhangai aimag, made a photographic catalogue of each rock art sites, determined its geographic coordination and other archaeological monuments using GPS in the area.

We worked mainly at the largest site which located in steep slope (275 m long and 40 m tall). The site is divided into 28 sections (each is 10x 40 m). In total, there were recorded 1176 images at 12 rock art sites in the Huremt. These included a variety of images with different styles.

The majority of images from Site-1 were of animals – deer, ibex and horses. Other images included wolves, dogs, camels, humans, horse, mating deer, knives and other tools and carts. In the Site 6 there are interesting images as a swastika and a scene of two people holding hands. The sites 2, 7, 10, 11 and 12 are located among kheregssuurs.

Conservation issues: Many of the rocks were weathered, with flaking surfaces, cracks and splitting. Also lots of rocks are damaged by animal such as scrapes from goat hooves and bird droppings and some of them damaged by human. According to our account around 22% of the rocks recorded in Site 1 have some marks made by human such as scratches, tracing the outline of old art, engraving new images. Sometimes ancient and modern images or lines can not easily be distinguished.